



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 08 өдөр

Дугаар А/91

Улаанбаатар хот

Хүнсний ногоо тариалах иргэдэд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хаврын тариалалтыг дэмжих бодлогын хүрээнд хүнсний нарийн ногоо тариалах хүсэлтэй иргэдэд дэмжлэг үзүүлэх ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтэс (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

2.Хүнсний ногооны үр олгоход шаардагдах хөрөнгийн төсвийг хавсралтаар баталсугай.

3.Тус арга хэмжээнд зарцуулах 895,757 (Найман зуун ерэн таван мянга долоон зуун тавин долоо) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон эргэн танилцуулахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д, тариалалтад олгох үрийг авч ирэх, тариалан эрхлэгчдэд олгох ажлыг шуурхай зохион байгуулж, тайлан, мэдээг тогтоосон хугацаанд холбогдох газарт хүргүүлж ажиллахыг Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн Ахлах мэргэжилтэн (Ё.Гэрэлцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны дүгээр сарын ны өдрийн
..... дугаар захирамжийн хавсралт



ХҮНСНИЙ НОГООНЫ ҮР ИРГЭДЭД ОЛГОХОД
ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Барааны нэр	Хэмжих нэгж	Олгох тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ (мян.төг)
1	Шар луван (Шантенэ 2461)	кг	3	16000	48,000
2	Шар манжин (Шведская желтая)	кг	0.5	17910	8,955
3	Хүрэн манжин (Бордо237)	кг	10	16,000	160,000
4	Бууцай (Хятад)	кг	0.2	25,000	5,000
5	Урт сонгино (Алтай)	кг	2	16,000	32,000
6	Чинжүү (Мордо)	кг	1	95,000	95,000
7	Бөөрөнхий сонгины хар үр ()	кг	0.1	80,000	8,000
8	Байцаа (Харрикейн)	уут/ш	1	95,921	95,921
9	Байцаа (Бронко)	уут/ш	1	95,921	95,921
10	Хүлэмжийн хэмх (зун 1000ш)	уут/ш	1	70,000	70,000
11	Лооль	кг	0.05	1,960,000	98,000
12	Бөөрөнхий сонгины төл үр (Штутгартер ризен)	кг	40	2,360	94,400
13	Саримс (Цагаан хальст)	кг	10	3,636	36,360
14	Шатахуун (А92)	л	20	2410	48,200
Нийт дүн					895,757